

БАРААНЫ АНГИЛАЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Ц.УРАНТУУЛЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн дууссан хугацаа	Биелэл-тийн хувь		
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)						
					1	2				3	4
Зорилт 1.1 Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх											
1	Барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт гүйцэтгэлээр	100	Тарифын болон тарифын бус зохицуулалт, татварын чөлөөлөлттэй холбоотой эрх зүйн актын төсөлд барааны ангиллын талаас санал өгөх, барааны ангиллын кодыг тодорхойлох;	1. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай 2024 оны хуулийн оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортлож байгаа түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн албан татвараас чөлөөлөх заалтыг нэг мөр хэрэгжүүлэх талаар чиглэл авахаар 2025.01.20-ны өдрийн 02/282 тоот албан бичгийг ХХААХҮЯ-нд хүргүүлсэн. Энэ асуудлыг шийдвэрлэх хүрээнд ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, ажилтан болон Оёдлын салбарын нэгдсэн холбооны төлөөлөл, ТОГ-тай хамтран уулзалт зохион байгуулж, яамнаас оёдлын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжийн нэрсийг ирүүлж байхаар тохиролцсон. 2. Тамхины хяналтын тухай хууль, Онцгой албан татварын тухай хуулиудад шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн буюу никотин агуулсан эсвэл тамхи, никотин орлуулагч агуулсан асаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүний заалтыг нэмж оруулахаар санал боловсруулж байгаатай холбоотойгоор 2404.12.00, 2404.19.00, 8543.40.00 кодуудад ангилагдах тамхин бүтээгдэхүүний "нэгж бүтээгдэхүүний шингэний агууламж" болон "нийт буюу тухайн нэг барааны тоо хэмжээнд харгалзах шингэний агууламж"-ийн хэмжээг оруулах талбарыг шинээр нээлгэх талаар дотоод зурвасыг МТГ-т хүргүүлсэн. 3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох ажилтнуудтай ГПГТХ-ийн 38.1.1 дэх заалтыг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор барааны жагсаалт гаргахтай холбоотой асуудлаар хийсэн уулзалтад ТОГ-ынхантай хамтран оролцсон. Одоогоор жагсаалтыг ирүүлээгүй байна. 4. ЭХЯ-наас Төв аймгийн Баян сумын нутагт баригдах Багахангайн 660 МВт-ын цахилгаан станцын төслийн хүрээнд импортоор оруулах тоног төхөөрөмжид ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жилийн хугацаагаар сунгах тухай ЗГ-ын 2025.05.07-ны өдрийн 221 дүгээр тогтоол батлагдсантай холбоотойгоор "Касен пауэр грийн энержи" ХХК-ийн					01.01-06.10	95

				импортлох нийт 1757 барааны жагсаалт ирүүлснийг судалж, зориулалт, гүйцэтгэх үйлдэл, хүчин чадлыг илэрхийлсэн үзүүлэлт болон хийсэн материал нь тодорхойгүй, ерөнхий нэртэй барааны талаарх нэмэлт тайлбар, тодруулгыг төслийн ажилтнаас цахимаар тухай бүр авч, нэр, зориулалт, техникийн үзүүлэлт, үнэ нь ижил тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нэгтгэн, хууль, тогтоолын заалтад хамаарахгүй машин механизм, техник хэрэгсэл, барилгын материалыг хасч, нийт 1603 нэр төрлийн барааны ангиллын кодыг БЦТ-ийн 2 ГУБ-ийн хамт тодорхойлон хариуг 2025.06.06-ны өдрийн 01/2423 тоот албан бичгээр ЭХЯ, СЯ-нд хүргүүлсэн. 5. ССАЖЗЯ-наас ГТГТТХ-ийн 38.1.19 дэх заалтын хүрээнд гаалийн албан татвараас чөлөөлөгдөх спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэлийг 3 бүлэг болгон шинэчлэн нийт 694 барааны жагсаалт ирүүлснийг судалж үзэн, спортын төрлөөрөө өөр боловч ижил нэртэй төхөөрөмж, хэрэглэлийг нэгтгэн, зарим спортын зориулалттай гэдгийг ялгах боломжгүй барааг хасах санал, мөн 49 барааны нэмэлт тайлбар, тодруулга авах асуултыг боловсруулан 2025.05.19-ний өдрийн 02/2086 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хариу тайлбарыг цахимаар 2025.06.04-ний өдөр ирүүлснийг судалж байна.		
2		95	Шаардлагатай тохиолдолд үндэсний код, хэмжих нэгжид нэмэлт, өөрчлөлт оруулах	Тайлант хугацаанд үндэсний кодоод нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зүйн үндэслэл, шаардлага гараагүй.	01.01-06.10	-
3		90	Уялдуулсан системийн хорооны шийдвэрийг орчуулан шийдвэрийн санг баяжуулах	УСХ-ны шийдвэрүүдээс Зүйл 20.08, 20.09, 21.06, 22.02, 24.04-ийн нийт 55 шийдвэрийг ЧХОУНБГГ-ын ГУБ Б.Энхжингийн хамт орчуулсан.	01.01-06.10	90
4		98	“Хиймэл оюун ухаанд суурилсан БТКУС-ийн код санал болгох платформ”-ын туршилтыг хийх	Платформын туршилтыг хийж үзэхэд тухайн бараа ангилагдах санал болгож байгаа кодууд гарахаас гадна хамааралгүй ангиллын кодууд гарч байсан тул энэ талаарх үр дүнг МТГ-ын ГУАБ Н.Мөнхзулд файлаар хүргүүлсэн. Мөн 2024 онд ангиллын код тодорхойлуулсан улсын чанартай томоохон 6 төслийн хүрээнд импортлох 4850 барааны бичиглэл, кодын мэдээллээр сан үүсгэн платформыг туршихаар файлыг хүргүүлсэн.	01.01-06.10	90

5				БТКУС-ийн тухай конвенц, түүний хавсралтыг "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хэвлүүлэх ажлыг зохион байгуулах	БТКУС-ийн конвенц, Тайлбар дүрэм, конвенцийн хавсралт болох жагсаалтын 2022 оны хувилбарыг "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хэвлүүлэх хэвлэлийн эх нийт 465 нүүр хуудсыг бэлтгэж дуусган ХХ-т дотоод зурвасаар хандан чиглэл авч, өгсөн чиглэлийн дагуу СЯ-нд 2025.03.18-ны өдрийн 01/1074 тоот албан бичгээр холбогдох байгууллагад уламжлуулахаар хүргүүлсэн. СЯ-наас УИХ-ын Тамгийн газарт хандах талаар чиглэл өгсөн тул 2025.05.07-ны өдрийн 01/1882 тоот албан бичгийг файлын хамт хүргүүлсэн. Гэвч конвенц болон хавсралтын орчуулгын баталгаажуулалтыг хийлгэсний дараа хэвлэх боломжтой талаар утсаар холбогдон мэдэгдсэн тул 2025.06.03-ны өдрийн 02/2349 тоот албан бичгийг файлын хамт ГХЯ-нд хүргүүлсэн. Одоогоор хариу ирээгүй байна.	01.01-06.10	95
6			98	Аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлтийг шийдвэрлэх	1.Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах 3 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, 2 аж ахуйн нэгж, байгууллагын ангиллын кодын тайлбар, тодруулга авах хүсэлт, 2 зохион байгуулалтын бүтцийн нэгжээс ирүүлсэн, нийт 21 барааны ангиллын талаарх хүсэлтийг шийдвэрлэж ажилласан. Үүнд: - [redacted] үүлсэн хүсэлтийн судалж үзэн экспортод гаргах хүрэн нүүрсний ангиллын кодын тайлбарыг 2025.02.21-ний 02-2/822 тоот албан бичгээр хүргүүлсэн. - Монополын эсрэг газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу "[redacted]" -ийн ангиллын кодын тайлбарыг 2025.02.24-ний 02-2/854 тоот албан бичгээр хүргүүлсэн. - "[redacted]" ас ирүүлсэн хүсэлтийн дагуу "[redacted]" "салст бүрхүүлийн тарилгын бэлдмэл" гэх 2 нэр төрлийн барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлж, 2025.02.28-ны өдрийн 02-2.1/934 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн. - Бичээч хариу [redacted] гэх барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлтийг судалж үзэхэд бараагаа гаалийн байгууллагад мэдүүлсэн байсан тул "Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журам"-ын дагуу урьдчилан тодорхойлох боломжгүй талаар хариуг 2025.03.21-ний 02-2.1/1133 тоот албан бичгээр хүргүүлсэн. Гэвч дахин 3 нэр төрлийн барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлтийг ирүүлснийг судалж үзэн 9304.00.00 кодоод ангилагдах талаарх хариуг 2025.04.03-ны өдрийн 02-2.1/1338 тоот албан бичгээр хүргүүлсэн. - [redacted] хүсэлтийн дагуу 4 нэр төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүнийн ангиллын кодыг тодорхойлсон. - ХБГ-аас ирүүлсэн дотоод зурвасын дагуу мотоциклын 7 ангиллын код, "үйлдвэр, агуулах, онгоцны буудлын зориулалттай ажлын тэрэг" гэх өөрөө явагч тээврийн хэрэгслийн 2 ангиллын кодыг хүргүүлсэн. - ГТЛ-оос ирүүлсэн дотоод зурвасын дагуу "[redacted]"-ийн импортлох БНСУ-д үйлдвэрлэсэн амин дэмийн ундаа "[redacted]" гэх барааны холбогдох бичиг баримтыг судалж үзэн ангиллын кодыг	01.01-06.10	95

					тодорхойлж, 2025.05.26-ны 02-2.1/193 тоот дотоод зурвасаар хариуг хрүгүүлсэн. 2.Аж ахуйн нэгж, иргэдэд ангиллын кодтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө нийт 16 удаа утсаар, биечлэн ирж уулзсан 3 аж ахуйн нэгжид зөвлөгөө өгсөн.			
7	Барааны ангилал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	98	7.Барааны ангиллын чиглэлээр гаалийн улсын байцаагч, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт сургалт зохион байгуулах	1.ГБМ-ий анхан шатны сургалтад 1 удаа, давтан сургалтад 3 удаа УС-ийн 2022 оны нэмэлт, өөрчлөлт, ангиллын алдаа гарч байгаа асуудалтай холбоотой мэдээллээр сургалт хийсэн. 2. ДГБ-аас зохион байгуулсан “УС ба ангиллын урьдчилсан шийдвэр” үндэсний сургалтын “Эм болон хүнсний бүтээгдэхүүн”, “Машин механизм” сэдэвт англи хэл дээрх танилцуулга материалыг орчуулахаас гадна сургалтын үеэр экспертийн нэмэлт тайлбарыг орчуулах ажлыг хийсэн. Мөн сургалтын бэлтгэл хангах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	01.01-06.10	90	
Зорилт 1.3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх								
8	Ангилалтай холбоотой маргаан, гомдлын шийдвэрлэлт, хяналт тавьсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	98	Барааны ангилалтай холбоотой ирүүлсэн санал, хүсэлт болон газар, хороодын даргын шийдвэрт гаргасан гомдол, маргааныг шийдвэрлэх, шийдвэрийн цахим санг баяжуулах	1.ХХК-ийн 2024 онд бүрдүүлэлт хийсэн 2 гаалийн мэдүүлгийг буцаасантай холбоотой захиргааны хэргийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах хариу тайлбар, үндэслэлийг боловсруулан Давж заалдах шатны шүүхэд хүргүүлсэн. Давж заалдах шатны шүүхийн 2025.03.11-ний өдрийн хурлаар хэлэлцэн, хуулийн заалтыг буруу хэрэглэсэн, гэрчээр оролцох боломжгүй этгээдийн мэдүүлгийг үндэслэн шийдвэр гаргасан гэж үзээд анхан шатны шүүхэд хэргийг дахин хянуулахаар буцааж шийдвэрлэсэн. Энэ захиргааны хэрэгтэй холбоотойгоор ДГБ-д 2024.09.04-ний өдөр 2 нэр төрлийн барааны ангиллын зөвлөмж авахаар албан захидал хүргүүлсний дагуу хүсэлтийн хариу албан захидал ирснийг орчуулан танилцуулга бэлтгэж МЗХ-аар 3 нэр төрлийн барааны ангиллын асуудлыг хэлэлцүүлэн, 2 барааны зөвлөмжийг бүрдүүлэлтэд хэрэгжүүлэх, 1 барааг УСХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. УСХ-нд хүргүүлэх нэмэлт материалыг бэлтгэх ажлыг хийж байна. Мөн "ХХК" гэх барааны экспортын гаалийн мэдүүлгийн хуулбар болон ангиллын байр суурийн талаар мэдээлэл авах хүсэлтийг БНСУ-ын гаальд ГХАХ-ээр дамжуулан хүргүүлсэн, одоогоор хариу ирээгүй байна. 2.ХХК-ийн 2024 онд бүрдүүлэлт хийсэн 2 гаалийн мэдүүлгийг буцаасантай холбоотой захиргааны хэргийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг судалж үзэн шийдвэрлэж, 2025.02.11-ний өдрийн 02-2.1/616 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.	01.01-06.10	95	

9	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	98	МУ, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах дараагийн хэлэлцээрийн бэлтгэл ажлыг хангахад оролцох	Монгол-Солонгосын ЭЗТХ-ийн "Барааны худалдаа"-ны дэд бүлэгт ажиллаж байна. Дараагийн хэлэлцээний бэлтгэл ажлын хүрээнд ЭЗХЯ-наас ирүүлсэн албан бичгийн дагуу гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтын 2, 4, 5, 6, 7, 8 оронгийн кодын бичиглэлийг монгол, англи, орос хэлээр бэлтгэн хариуг файлаар хүргүүлсэн. Мөн ДХБ-ын Тариф, худалдааны мэдээллийн нэгдсэн цахим сан (Integrated Data Base-IDB)-д МУ-ын импортын барааны 2023 оны гаалийн нэн тааламжтай тарифын жагсаалтад нийт 6371 ангиллын код, бичиглэл байгаа нь нэг кодоод ангилагддаг боловч импортлох хилийн боомт, хугацаанаас нь хамааруулан ялгавартай тариф тогтоосон бараа болох гурил, онгоцны бензин, түлшний 26 код давхардаж оруулсан болон хүчингүй болсон 11 код орсонтой холбоотой талаар тайлбарыг хүргүүлсэн.	01.01-06.10	94
10	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт		98	ДГБ-ын Уялдуулсан системийн хорооны хуралдаанд оролцох, холбогдох шийдвэрийг орчуулах	ДГБ-ын Уялдуулсан системийн хорооны 75 дугаар хуралдаанд 3-р сарын 10-21-ний өдрүүдэд цахимаар оролцсон. Шийдвэрийг орчуулах ажлыг сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөж байна.	01.01-06.10	90
11	Үүрэг даалгаврын биелэлт		-		- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн барааны ангилалтай холбоотой заалтын хэрэгжилтийг 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн байдлаар гарган ХХ-т, ХХХ-ийн Урьдчилсан шийдвэртэй холбоотой заалтын хэрэгжилтийг ЭУХ-т тус тус хүргүүлсэн. - ЗУГ-аас ирүүлсэн дотоод зурвасын дагуу ГТХ, ГТГТХ-ийн барааны ангилалтай холбоотой зүйл, заалтыг гаргаж өгсөн.	01.01-06.10	90
12	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт		-	Цаг үеийн шинжтэй арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах	МЗХ-аас гарсан шийдвэрийн дагуу ДГБ-д барааны ангиллын асуудал хэлэлцүүлэхтэй холбогдуулан албан захиа хүргүүлж, УСХ-ны 9 дүгээр сард хуралдах 76 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэх саналаа хүргүүлсэн. Мөн ДГБ-аас ирүүлсэн ангиллын зөвлөмжийн хүрээнд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал асуулгыг ДГБ-д бэлтгэн хүргүүлээ. ДГБ-аас хариу албан захиа ирүүлсний дагуу бэлтгэл ажлын хүрээнд бараатай холбоотой зарим нарийвчилсан үзүүлэлт, техникийн зохицуулалтын талаар холбогдох тайлбарыг хүргүүлэхээр бэлтгэж байна.	01.01-06.10	90
12	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт		-	Цаг үеийн шинжтэй арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах	ГЕГ-ын даргын баталсан БЦТ-ийн 2023, 2024 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэгт ажилласан. Ажлын хэсгийн хүрээнд гомдол, маргааны шийдвэрлэлт, барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлж байгаа байдал, ангиллын алдааг бууруулах чиглэлээр хийсэн ажилд нь үнэлгээ, дүгнэлт өгсөн.	01.01-06.10	95

13	Ажлын цаг ашиглалт			Эхний хагас жилд ажлын цагийн хоцролт, тасалдалгүй ажилласан. Нийт 2410 минут буюу 40.16 цаг илүү ажилласан.	01.01-06.10
----	--------------------	--	--	--	-------------

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Гүйцэтгэлийн түвшин						
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа Биелэл-тийн хувь
	1	2	3	4	5	6 7
1	ДГБ-аас боловсруулан гаргасан бичиг баримтыг судалж, барааны ангиллын мэдлэг чадвараа дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна	- ДГБ-ын цахим хуудсанд гишүүний эрхээр нэвтрэн мэдээ, мэдээллийг тухай бүр авч ажиллаж байна. Мөн УС-ийн Жагсаалт, Тайлбар бичгийн цахим англи хувилбарыг ажилдаа байнга ашиглаж байна. - УСХ-ны 75 дугаар хуралдаанд 3 дугаар сарын 10-21-ний өдрүүдэд цахимаар оролцож, барааны ангиллын мэдлэг, чадвараа дээшлүүлсэн.	01.01-06.10 95
2	ДГБ-ын МУ-д зохион байгуулах барааны ангиллын сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна	ДГБ-аас 5 дугаар сарын 19-23-ны хооронд зохион байгуулсан "УС ба ангиллын урьдчилсан шийдвэр" үндэсний сургалтад бүрэн хамрагдаж, барааны ангиллын тайлбар дүрэм, УСХ-ны үйл ажиллагаа, ангиллын урьдчилсан шийдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, эм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, нэхмэл, машин механизмын кодын талаар нарийвчлан судалж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Мөн БНСУ-ын ангиллын урьдчилсан шийдвэр гаргадаг туршлагыг судалсан.	05 сар 95
3	БНСУ-д зохион байгуулагдах барааны ангиллын сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна	БНСУ-ын Чёнан хотод 04 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Олон улсын гаалийн ажилтнуудад зориулсан УС-ийн сургалт"-д хамрагдаж, бусад 8 орны гаалийн байгууллагын барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлж буй туршлага, тулгамдаж буй асуудлуудаас суралцсан. Ялангуяа БНСУ-ын гаалийн байгууллагын УС-ийн бүтэц, зохион байгуулалт, бодлого чиглэлийн талаар өргөн хүрээний мэдээлэлтэй болж, гаалийн төв лаборатори болон сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцан, ангиллын кодын маргаан гардаг бараануудын талаар саналаа солилцож, тайлбар дүрмийг хэрэглэх асуудлыг жишээтэй хослуулан мэдлэгээ дээшлүүлсэн.	04 сар 95

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАРААНЫ АНГИЛАЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
 ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

...../Ц.УРАНТУУЛ/

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЦЭГМИДИЙН УРАНТУУЛЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Барааны ангилал, үнэлгээний хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1.1 Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх					
1	Тарифын болон тарифын бус зохицуулалт, татварын чөлөөлөлттэй холбоотой эрх зүйн актын төсөлд барааны ангиллын талаас санал өгөх, барааны ангиллын кодыг тодорхойлох	58	9	67	
2	Уялдуулсан системийн хорооны шийдвэрийг орчуулах, шийдвэрийн санг баяжуулах	54	9	63	
3	Хиймэл оюун ухаанд суурилсан БТКУС-ийн код санал болгох платформ"-ын туршилтыг хийх	54	9	63	
4	БТКУС-ийн тухай конвенц, түүний хавсралтыг "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хэвлүүлэх ажлыг зохион байгуулах	58	9	67	
5	Аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлтийг шийдвэрлэх	58	9	67	
6	Барааны ангиллын чиглэлээр гаалийн улсын байцаагч, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт сургалт зохион байгуулах	54	9	63	
Зорилт 1.3 Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх					
7	Барааны ангилалтай холбоотой ирүүлсэн санал, хүсэлт болон газар, хороодын даргын шийдвэрт гаргасан гомдол, маргааныг шийдвэрлэх, шийдвэрийн цахим санг баяжуулах	58	9	67	
8	Монгол Улс, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах дараагийн хэлэлцээний бэлтгэл ажлыг хангахад оролцох	57	9	66	
9	ДГБ-ын Уялдуулсан системийн хорооны хуралдаанд оролцох, холбогдох шийдвэрийг орчуулах	54	9	63	
10	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	54	9	63	
11	Үүрэг даалгаврын биелэлт	55	8	63	

12	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	58	9	67	
13	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
Дундаж оноо:				65.2	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1	ДГБ-аас боловсруулан гаргасан бичиг баримтыг судалж, барааны ангиллын мэдлэг чадвараа дээшлүүлэх	95	14.2	
2	ДГБ-ын МУ-д зохион байгуулах барааны ангиллын сургалтад хамрагдах	95	14.2	
3	БНСУ-д зохион байгуулагдах барааны ангиллын сургалтад хамрагдах	95	14.2	
Дундаж оноо:			14.2	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1	Хандлага, ёс зүй	7	
2	Асуудал шийдвэрлэх	7	
3	Хариуцлагатай байдал	7	
4	Дүн шинжилгээ хийх	7	
5	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар		
Дундаж оноо:		7.0	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (хамт олны үнэлгээ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	
1	Хандлага, ёс зүй	8
2	Багаар ажиллах	8
3	Харилцаа	8
Дундаж оноо:		8.0

5. Гүйцэтгэлийн үнэлгээ


Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
-----	---------------------	--------------------------

1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	65.2
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14.2
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		94.4

Үнэлгээ өгсөн:

Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

Нэгжийн дарга


.....
(гарын үсэг)

/Ч.Чимгэрэл/


.....
(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Гаалийн улсын байцаагч
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:


.....
(гарын үсэг)

/Ц.Урантуул/


(албан хаагчийн нэр)


.....
(огноо)


Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Г.Энхтайван/


.....
(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)


/Ө.Тэгшээ/


.....
(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Дарга
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч


.....
(гарын үсэг)

/Р.Отгонжаргал/


.....
(огноо)

